

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шим-Ус ОНӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/02/НА-СТА-ОНӨ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот

2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Д.Эрдэнэцэцэг

Утас: 70432545

цахим хаяг: erdenetsetsegd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	6
3. Аудитын тайлан .....	6
3.1 Ерөнхий зүйл.....	6
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	7
3.4 Материаллаг байдал .....	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.6 Зорилтот түвшин, эдийн засгийн үндсэн үзүүлэлт .....	9
3.6 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	9
3.7 Аудитын гол асуудал .....	9
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	10
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	10
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	10
3.10 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	10
4. Аудитын илрүүлэлт.....	10
4.1 Залруулсан алдаа.....	10
4.4 Зөвлөмж .....	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	12

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНӨ	Орон нутгийн өмч
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УСУГ	Ус сувгийн удирдах газар
ЗЗ	Зохицуулах зөвлөл
ХХК	Хариуцлагатай хувьцаат компани
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
64000 Цамбагарав бөс, Жаргалант сум, Ховд  
Утас: 876-70433061, Факс: 876-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

"ШИМ-УС" ОНӨҮГ-ЫН  
ДАРГА Н.ГАНБАТ ТАНАА

2022.05.15 № 2/122  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шим-Ус ОНӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шим-Ус ОНӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний тайланг Компанийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний тайланг Компанийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

  
Х.БОЛДБААТАР

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/ төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>656,948,169</b>	<b>828,310,069</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	7,062,944	36,981,497
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	126,135	113,235
31110	Төгрөг	126,135	113,235
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	6,936,809	36,868,261
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	6,936,809	36,868,261
31213	Арилжааны банк дахь харилцах	6,936,809	36,868,261
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	213,400,116	250,215,976
33300	Татаас, санхүүжилтийн авлага	213,400,116	250,215,976
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	436,485,110	541,112,596
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	54,198,606	100,070,192
35110	Тусгай зориулалттай материал	54,198,606	100,070,192
35300	Бэлэн бүтээгдэхүүн	102,996,422	128,907,453
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	279,290,082	312,134,951
35430	Сэлбэг хэрэгсэл	279,290,082	312,134,951
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>656,948,169</b>	<b>828,310,069</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	656,948,169	<b>828,310,069</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	4,978,244,306	5,715,078,581
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,736,028,100	5,253,585,535
39202	Хуримтлагдсан элэгдэл	(364,507,282)	(460,044,509)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	147,691,828	503,091,828
39204	Хуримтлагдсан элэгдэл	(144,358,495)	(166,175,161)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,653,897,623	1,696,869,687
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,053,255,802)	(1,113,851,732)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,044,000	14,694,000
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,295,667)	(13,091,067)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	5,153,974,900	5,153,974,900
39301	Программ хангамж	9,050,000	9,050,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	(9,050,000)	(9,050,000)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,153,974,900	5,153,974,900
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>10,789,167,375</b>	<b>11,697,363,550</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>24,371,014</b>	<b>66,406,641</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	24,371,014	33,203,320
<b>413</b>	<b>Өглөг</b>	24,371,014	33,203,320
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	24,371,014	33,203,320
41363	Татварын өглөг /ОНӨҮГ/	14,800,065	33,203,320
41366	Дансны өглөг /ОНӨҮГ/	9,570,949	-
<b>42</b>	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	24,371,014	33,203,320
<b>422</b>	<b>Урт хугацаат зээл</b>	-	928,343,809
<b>4222</b>	<b>Гадаад валют</b>	928,343,809	928,343,809

42230	Бусад урт хугацаат өр төлбөр /ОНӨҮГ/	928,343,809	928,343,809
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>952,714,823</b>	<b>961,547,129</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	10,534,213,139	11,433,577,007
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	10,784,722,427	11,435,179,862
51101	Өмч: - төрийн	10,086,961,840	10,086,961,840
51105	Нэмж төлөгдсөн капитал	697,760,587	697,760,587
51106	Эздийн өмчийн бусад хэсэг		650,457,435
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(948,269,876)	(948,269,876)
51600	Тайлант үеийн үр дүн		248,906,434
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>10,789,167,375</b>	<b>11,697,363,550</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,764,643,694</b>	<b>1,976,020,404</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,764,643,694</b>	<b>1,976,020,404</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,764,643,694</b>	<b>1,976,020,404</b>
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ОНӨҮГ/	1,764,643,694	1,976,020,404
120011	Борлуулалтын өртөг /ОНӨҮГ/	1,725,495,821	1,543,086,111
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,650,047,903</b>	<b>1,727,113,971</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,650,047,903</b>	<b>1,727,113,971</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,650,047,903</b>	<b>1,727,113,971</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,457,482,748	1,727,113,971
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,457,482,748	1,727,113,971
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	192,565,155	184,027,860
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	192,565,155	184,027,860
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>114,595,792</b>	<b>248,906,434</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>114,595,792</b>	<b>248,906,434</b>

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	6,506,692,761	489,814,187	(1,062,865,667)	3,485,000,000	9,418,641,281
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	3,485,000,000	-	-	(3,485,000,000)	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,991,692,761	489,814,187	(1,062,865,667)	-	9,418,641,281
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	114,595,792	-	114,595,792
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,991,692,761	489,814,187	(948,269,876)	-	9,533,237,073

D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	9,991,692,761	489,814,187	(833,674,084)	-	
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	95,269,079	207,946,400	-	-	303,215,479
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,086,961,840	697,760,587	(948,269,876)	-	9,836,452,552
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	248,906,434	650,457,435	899,363,869
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,086,961,840	697,760,587	(699,363,442)	650,457,435	10,735,816,420

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,010,028,816	2,224,597,675
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,010,028,816	2,224,597,675
120	Нийтлэг татварын бус орлого	2,010,028,816	2,224,597,675
120009	Бусад орлого	-	67,130,088
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ОНӨҮГ/	2,010,028,816	2,157,467,587
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,005,610,650	2,191,679,122
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,005,610,650	2,191,679,122
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,005,610,650	2,191,679,122
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	650,644,004	704,727,023
210106	Ажиллагчдад төлсөн /ОНӨҮГ/	650,644,004	704,727,023
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	171,026,591	203,978,497
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ОНӨҮГ/	171,026,591	203,978,497
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	422,816,110	259,458,486
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ОНӨҮГ/	422,816,110	259,458,486
2104	Хангамж, бараа материалын зардал	398,578,825	746,368,064
210402	Тээвэр, шатахуун	34,773,251	48,020,663
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ОНӨҮГ/	363,805,574	698,347,401
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	362,545,121	280,147,052
210816	Татварын байгууллагад төлсөн /ОНӨҮГ/	316,615,712	246,582,092
210817	Даатгалын төлбөрт төлсөн /ОНӨҮГ/	2,557,790	1,260,000
210818	Бусад мөнгөн зарлага /ОНӨҮГ/	43,371,619	32,304,960
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	4,418,166	29,918,553
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ОНӨҮГ/	-	222,500,000
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	4,418,166	29,918,553
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,644,778	7,062,944
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,062,944	36,981,497

## 2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2020 оны Гүйцэтгэл	2021 он		Харьцуулалт	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
А	Үйлдвэрлэсэн: Цэвэр бохир ус	49,335	53,893	62,506	8,613	0.16
	Түгээсэн: Цэвэр бохир ус	48,328	52,850	61,340	8,490	0.16
	Нийт орлого :	2,010,028,816	1,998,483,000	2,210,415,262	200,386,446	0.32
	Үүнээс: Цэвэр борлуулалт	1,962,010,665	1,930,153,000	2,024,882,718	62,872,053	0.24
Б	Үйл ажиллагааны бусад орлого	48,018,151	68,330,000	185,532,544	137,514,393	105.37
	Нийт зардал	1,882,700,159	1,979,368,100	2,180,501,709	297,801,550	(0.01)
	Үүнээс: Удирдлагын зардал	74,612,700	277,225,000	434,456,327	359,843,627	(0.02)
В	Татварын өмнөх ашиг	127,328,657	21,026,390	276,562,704	149,234,047	(1.21)
	Цэвэр ашиг / алдагдал /	114,595,791	19,114,900	248,906,433	134,310,642	(1.21)
	Төрийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-
	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	1	1	1	(0.18)	(0.25)
	Нийт авлага	213,400,115	-	250,215,977	36,815,862	1.26
	Нийт өглөг	24,371,014	-	33,203,320	8,832,306	0.15
	Богино хугацаат өр төлбөр	24,371,014	-	33,203,320	8,832,306	0.15
	Урт хугацаат өр төлбөр	928,343,809	-	928,343,809	-	
	Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт	37,035,079	238,500,000	222,500,000	185,464,921	(0.02)
	Нийт ажиллагсдын тоо	84	79	107	23	(0.01)
	Нийт цалингийн сан	726,004,300	799,985,000	742,588,833	16,584,533	0.05
	Нэг ажилтны дундаж цалин	720,242	843,866	578,340	(141,902)	0.06

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Шим-Ус ОНӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал

татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өглөг авлага, Засгийн газрын 43 тоот тогтоолын хэрэгжилт, зардалтай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор Д.Эрдэнэцэцэг 2022 оны 03 дугаар сарын 05-наас 2022 оны 03 дугаар сарын 15-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 24-ны өдрийн 19 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Шим-Ус ОНӨҮГ-ийн газар нь:Ховд хотынхоо хүн амын тав тухтай амьдрах, ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө аймаг орон нутгийн тогтвортой хөгжлийн бодлого,үзэл баримтлалыг хэрэгжүүлэн стандартад тохирсон усыг түгээж хэрэглээний явцад гарсан бохир усыг татан зайлуулахад хөнгөн шуурхай сэтгэл ханамжтай үйлчилгээ үзүүлэх эрхэм зорилт дэвшүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

**Үйл ажиллагааны чиглэл:** Эвсэг, чадварлаг, мэргэжлийн хамт олон бидний баялаг, тэгш хүртээмжтэй шударга ёс зүйг эрхэмлэх, хэрэглэгчид хамтрагч байгууллагуудын итгэлийг хүлээх, мэргэжлийн түвшинд хариуцлагатай чанартай гүйцэтгэл гэсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ✓ *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*
- ✓ *Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 тоот “Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоол,*
- ✓ *Ус сувгийн удирдах газрын тогтоол Шим-Ус ОНӨҮГ-ын эзэмшлийн цэвэр бохир ус түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах цэвэр бохир усны үнэ тариф,*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн,тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор Ус сувгийн удирдах газрын хяналт, шинжилгээ, дотоод аудитын газраас 2020-2021 онуудад Засгийн газраас үзүүлж буй хөнгөлөлтөд хамрагдаж буй айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудын тооцоо, 2022 оны 2 дугаар сард 2021 оны үйл ажиллагаанд дотоод аудитын хяналтыг хэрэгжүүлж хоорондын тооцоог хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шим-Ус ОНӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 1530.1 сая төгрөгөөс 1 хувиар тооцон 15.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 12.2 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Шим-Ус ОНӨҮГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 11697.3 сая төгрөг болж өмнөх оноос 908.1 сая төгрөгөөр буюу 15 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, бараа материалын данс байна.

Тайлант оны эхэнд 7.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол оны эцэст 36.9 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна

Авлага оны эхэнд 213.4 сая төгрөг байсан бол оны эцэст 250.2 сая төгрөг болж 36.8 сая төгрөгөөр өссөн байна. Үүнээс 191.2 сая төгрөгийг Засгийн газрын 211 дүгээр тогтоолын дагуу УСУГ-аас авах авлага, 59.0 сая төгрөгийн авлага нь төсөвт байгууллага, аж ахуйн нэгж бусад харилцагчдаас авах авлага байна.

Авлага дансны үлдэгдлийн 191.2 сая төгрөгийн авлага ЗГ-ын тогтоолын дагуу усны хөнгөлөлтийн авлага бөгөөд тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 541.1 сая төгрөг болж 104.6 сая төгрөгөөр нэмэгдэж 396.7 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч 292.1 сая төгрөгийн материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө оны эцэст 12622.2 сая төгрөг болж өмнөх оноос 911.6 сая төгрөгөөр өссөн байгаа нь ИТХ-ын 2021 оны 12-р сарын 600 тоот тогтоолоор 270.4 сая төгрөгийн хөрөнгө худалдан авах, 140 тоот тогтоолоор үнэ төлбөргүй хөрөнгө орлого авах 650.4 сая төгрөг нийт 920.8 сая төгрөгийн хөрөнгө орлого авч, ИТХ-ын 2021 оны 12-р сарын 15-ны 115 тоот тогтоолоор 9.3 сая төгрөгийн хөрөнгө акталж данс бүртгэлээс хассан байна.

Тайлант оны эхэнд 24.4 сая төгрөгийн өр төлбөртэй байсан бол оны эцэст 33.2 сая төгрөг болж 8.8 сая төгрөгөөр өссөн нь татварын өр 8.8 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой өглөг байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 10735.8 сая төгрөг болж 899.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 248.9 сая төгрөгийн ашигтай ажиллаж, эздийн өмчийн бусад хэсэгт аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 650.5 сая төгрөгийн үнэ төлбөргүй хөрөнгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

### **3.6 Зорилтот түвшин, эдийн засгийн үндсэн үзүүлэлт**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3,20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Шим-Ус ОНӨҮГ-ын гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрчим хүчний тухай хуулийн 6.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоол, аймгийн ИТХ-ын 2021 оны 12-р сарын 01-ны өдрийн 79 тоот тогтоолоор Шим-Ус ОНӨҮГ-ын техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөөг баталсан байна.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Шим-Ус ОНӨҮГ-ын 2021 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн орлогыг 1998.5 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1702.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 79 тоот тогтоолоор Шим-Ус ОНӨҮГ-ын 2021 оны төсвийг 1998.5 сая төгрөгөөр батлан ирүүлжээ.

#### **3.6.2 Зорилтот түвшний гүйцэтгэл**

Тайлант онд борлуулалтын орлого 1930.1 сая, үйл ажиллагааны бус орлого 68.3 сая төгрөг нийт 1998.5 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр айл өрх, төсөвт байгууллага, аж ахуйн нэгжээс 154.4 сая төгрөг Засгийн газрын тогтоолоор цэвэр бохир усны хөнгөлөлт 1776.8 сая төгрөг, халуун усны орлого 69.9 сая, ухаалаг усангийн орлого 23.8 сая, техникийн нөхцөл 10.4 сая төгрөг, бохирын хөлс 55.3 сая төгрөг, ОН-ийн өмч ашиглуулсан түрээс 29.4 сая төгрөг ОНХС-аас 4.0 сая төгрөг, бусад 86.4 сая төгрөг нийт 2210.4 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Шим-Ус ОНӨҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг төлөвлөгөөнөөс цэвэр бохир усны үйлдвэрлэлт 8613 тн, түгээлт 8490 тн илүү буюу 15.7-15.8 хувиар өссөн, нийт орлогыг 211.9 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн, нийт зардлыг 36.9 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан зэрэг үзүүлэлттэй байна.

### **3.6 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АДБОУС 706.7-д тодорхойлсноор үүссэн асуудал нь хэрэглэгчдэд хамааралтай ЗГ-ын 211 дүгээр тогтоолын дагуу орон нутгийн усны тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудаар дамжуулан сумдад олгосон цэвэр усны хөнгөлөлт чөлөөлөлтийн санхүүжилтийг ухаалаг худгаар үйлчлүүлж байгаа хүн амын тоог хянаж гүйцэтгэлээр санхүүжилт олгоогүйгээс илүү санхүүжилт авч зориулалт бус зарцуулах нөхцөл бүрдсэн байна.

#### **3.7 Аудитын гол асуудал**

Тайлант хугацаанд ЗГ-ын ковид-19 цар тахлын үед “айл өрх, аж ахуйн нэгж байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” 211 дүгээр тогтоолын дагуу цэвэр бохир усны хөнгөлөлт, чөлөөлөлтийн санхүүжилтийг олгосноор орлого өсөж санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлсэн байна.

### **3.8 Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа**

Төлөөлөн удирдах зөвлөл нь хуульд заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Эрчим хүчний яам, Хувьцаа эзэмшигчдийн төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч 3, хараат бус 3, ТУЗ-ын нарийн бичиг 1, нийт 7 гишүүнтэйгээр үйл

ажиллагаагаа явуулж, ТУЗ нь 2021 онд 5 удаа цахим хуралдаж, 15 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

ТУЗ-ын үйл ажиллагааны зардалд 2021 онд нийт 45.3 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 45.3 сая төгрөгийн зардлыг гаргасан байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 172 мэдээллээс 152 хугацаандаа оруулсан 2 мэдээлэл хугацаа болоогүй, 18 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Ус сувгийн удирдах газрын дотоод аудитаас салбарын харьяа байгууллагуудын 2021 оны “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтэд 2022 онд хийгдсэн аудитаар 98.1 хувьтай дүгнэгдсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 7.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1.9 сая төгрөгийн төлбөрийн акт, 5.2 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгөгдсөн нь 90% биелсэн байна.

### **3.10 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар ОНӨҮГ-ын худалдан авах ажиллагаа, дотоод хяналт, сумдад олгосон усны хөнгөлөлт, борлуулалт, бараа материалын зарцуулалттай холбоотой асуудлуудыг анхааран үзэх нь зүйтэй байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 189.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс төсвийн орлого бүрэн төвлөрүүлээгүй 10.3 сая төгрөгийн 2 зөрчилд 1 төлбөрийн акт, 29,8 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч үр дүнд 149.7 сая төгрөгийн 1 залруулга хийлээ.

#### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой залруулга хийгдсэн болно. Үүнд:

*Илрүүлэлт: Санхүүгийн тайлангийн үр дүнд жинхэнэ зарлага зөрүүтэй илэрхийлэгдсэн 149.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн*

стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалтыг мөрдөөгүй

Шийдвэрлэлт: Санхүүгийн тайланд 2022 оны „сарын,,өдрийн „,тоот албан тоотоор залруулга хийсэн

## 4.2 Төлбөрийн акт

**4.2.1 Илрүүлэлт:** Цалингийн зардал зөрүүтэй илэрхийлэгдсэн, хүн амын орлогын албан татвар суутгаж аваад төсөвт төлөөгүй 5.5 сая төгрөгийн зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах, Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх орлого бүрэн төвлөрүүлээгүй 5.5 сая төгрөгийн цалингийн ашгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох

**4.2.2 Илрүүлэлт:** Эскаватор тракторыг байгууллага, хувь хүнд эзэмшүүлснээр 12.1 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн бөгөөд 40%-ийг орон нутгийн өмчид төвлөрүүлээгүй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 02-р сарын 18-ны 49 тоот тогтоолын 2 дугаар заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Орон нутгийн өмчийг бусдад ашиглуулснаас олсон 40%-ийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй 4.8 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох

## 4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 4.3.1 Хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй, өмч хамгаалах комиссын дотоод хяналт сул, бараа материалын дансанд үндсэн хөрөнгө болох хөрөнгүүд бүртгэлтэй, хөрөнгийн бүртгэлийг стандартын дагуу бүртгээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцээгүй

Өгсөн зөвлөмж: Байгууллагын үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг чанартай гүйцэтгэж стандартын дагуу ангилан бүртгэх

### 4.4.3 Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу батлагдсан төсвийн 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж үр ашигтай ажиллах талаар авч хэрэгжүүлэх зүйл заалтуудын хэрэгжилт хангалтгүй байгаа 133.3 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны 43 дугаар тогтоолын 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт

зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны 43 дугаар тогтоолын 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох тогтоол журмыг мөрдөн ажиллах,  
Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 5 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Шим-Ус ОНӨҮГ	6	189.9	1	149.7	1	10.3			3	29.8

## ХОВД АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР